

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Давст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2023/92/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Улаангом хот  
2023 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,  
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь  
Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn  
Аудитын менежер: М.Бат-Амгалан  
Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn  
Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн "Увс Финанс аудит" ХХК  
аудитор: Я.Тунгалаг  
Утас: 99459698 Цахим хаяг: anu\_gantun@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**УВС АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,  
Ө.Бадрахын гудамж  
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,  
E-mail: uvs@audit.gov.mn

2023.02.24 № УВА-2023/92/НА-СТА-ТМЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ДАВСТ СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ Н.ЖАРГАЛСАЙХАН  
ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Давстсумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Давст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Боловсрол шинжлэх ухааны яамнаас үнэ төлбөргүй 920.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 4,849.4 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 4,367.8 мянган төгрөгийн ном ирж, төсвийн хөрөнгөөр 11,989.0 мянган төгрөгийн машин, тоног төхөөрөмж худалдаж авсан байна.

**Аудитын гол асуудал**

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

0200200506

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБООС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	
Асуудлыг онцолсон хэсэг .....	
Аудитын гол асуудал .....	
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	
4.1 Ерөнхий зүйл.....	
4.2 Материаллаг байдал .....	
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	
4.5.1 Завсрын аудитын талаар.....	
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн .....	
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	
5.1 Залруулсан алдаа.....	
5.2 Төлбөрийн акт .....	
5.3 Албан шаардлага.....	
5.4 Зөвлөмж .....	
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НА	Нийцлийн аудит

**2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

**2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

*/Төгрөг/*

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>78,966,326.58</u></b>	<b><u>97,006,919.17</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	00.00	2,103,276.29
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	00.00	2,103,276.29
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	00.00	2,103,276.29
31211	Төрийн сангийн харилцах	00.00	2,103,276.29
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	103,746.64	3,389,371.55
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	00.00	3,389,371.55
3351	Байгууллагаас авах авлага	00.00	3,389,371.55
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	78,862,579.94	91,514,271.33
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	608,500.00	248,500.00
35130	Эм боох материал	248,500.00	248,500.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	78,254,079.94	91,265,771.33
35410	Бичиг хэргийн материал	11,626,505.82	13,469,755.82
35420	Аж ахуйн материал	18,960,378.00	18,960,378.00
35440	Түлш, шатах тослох материал	737,426.54	882,170.43
35460	Хүнсний материал	2,705,945.58	7,842,804.58
35470	Бусад хангамжийн материал	43,965,324.00	50,110,662.50
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,713,012,862.55</u></b>	<b><u>1,652,434,389.04</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,713,012,862.55	1,652,434,389.04
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,664,818,862.55	1,604,299,409.04
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,587,056,604.75	1,587,056,604.75
39202	Хуримтлагдсан элэгдэл	-92,059,960.85	-145,372,057.41
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	238,638,301.87	238,241,877.25
39206	Хуримтлагдсан элэгдэл	-159,296,514.89	-162,218,463.64
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	148,245,135.65	134,473,481.14
39208	Хуримтлагдсан элэгдэл	-72,272,644.12	-66,757,849.71
39217	Ном	14,507,940.14	18,875,816.66
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	48,194,000.00	48,134,980.00
39301	Програм хангамж	890,000.00	890,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-710,000.00	-770,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	48,014,000.00	48,014,980.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>1,791,979,189.13</u></b>	<b><u>1,749,441,308.21</u></b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	1,123,610.39	22,000.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	1,123,610.39	22,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	1,123,610.39	22,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>1,790,855,578.74</u></b>	<b><u>1,749,419,308.21</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,790,855,578.74	1,749,419,308.21
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	395,974,482.50	395,975,462.50
51101	Өмч: - төрийн	395,974,482.50	395,975,462.50
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	1,168,319,057.52	1,126,881,806.99
51210	Өмнөх үеийн үр дүн	1,168,319,057.52	1,168,319,057.52

51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-41,437,250.53
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	226,562,038.72	226,562,038.72
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,791,979,189.13</b>	<b>1,749,441,308.21</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,559,918,539.68</b>	<b>790,313,484.02</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>950,795,426.68</b>	<b>13,700,284.02</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	950,795,426.68	13,700,284.02
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	950,795,426.68	13,700,284.02
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	912,600.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	950,795,426.68	12,787,684.02
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>78,650,413.00</b>	<b>776,613,200.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	00.00	642,849,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	642,849,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	4,751,513.00	2,550,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	2,550,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,751,513.00	
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	73,898,900.00	131,213,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	73,898,900.00	131,213,700.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>742,403,542.05</b>	<b>831,750,734.55</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>669,701,952.83</b>	<b>831,750,734.55</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	654,687,901.39	803,642,154.97
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	421,426,599.00	490,617,163.02
210101	Үндсэн цалин	279,362,285.00	353,384,666.98
210102	Нэмэгдэл	102,092,276.00	119,941,891.55
210104	Урамшуулал	29,892,038.00	13,930,604.49
210105	Гэрээт ажлын хөлс	10,080,000.00	3,360,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	55,052,171.56	62,037,592.78
210201	Тэтгэврийн даатгал	38,194,971.56	42,261,499.94
210202	Тэтгэмжийн даатгал	4,214,300.00	4,938,023.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,371,400.00	3,950,448.54
210204	Ажилгүйдлийн даатгал	843,000.00	989,799.03
210205	Эрүүл мэндийн даатгал	8,428,500.00	9,897,821.37
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	58,008,769.73	100,029,708.03
210301	Гэрэл, цахилгаан	5,343,792.99	6,323,428.03
210302	Түлш, халаалт	52,364,976.74	93,406,280.00
210303	Цэвэр, бохир ус	300,000.00	300,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	7,261,346.00	8,217,006.11

210402	Тээвэр, шатахуун	2,750,900.00	6,296,756.11
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,951,446.00	1,920,250.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>24,030,351.93</b>	<b>38,023,486.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	602,455.00	360,000.00
210502	Хоол, хүнс	23,427,896.93	37,663,486.00
<b>2106</b>	<b>Эд хөгшил, урсгал засварын зардал</b>	<b>850,000.00</b>	<b>1,358,374.00</b>
210604	Урсгал засвар	850,000.00	1,358,374.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,307,700.00</b>	<b>5,416,500.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,304,500.00	907,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	600,000.00	4,508,900.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>85,415,163.17</b>	<b>97,942,325.03</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	10,227,750.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,210,013.00	5,000,750.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	83,205,150.17	82,713,825.03
<b>212</b>	<b>ТАТААС</b>	<b>00.00</b>	<b>52,000.00</b>
<b>2121</b>	<b>Төрийн өмчит байгууллагад олгох татаас</b>	<b>00.00</b>	<b>52,000.00</b>
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	00.00	52,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>15,014,051.44</b>	<b>28,056,579.58</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>12,533,978.44</b>	<b>28,056,498.00</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	38,500.00	
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	11,299,478.44	21,929,404.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,196,000.00	6,127,094.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>2,480,073.00</b>	<b>00.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		0.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>00.00</b>	<b>81.58</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	81.58
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>72,701,589.22</b>	<b>00.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>72,701,589.22</b>	<b>00.00</b>
220001	Барилга байгууламж	72,701,589.22	00.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>817,514,997.63</b>	<b>-41,437,250.53</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>817,514,997.63</b>	<b>-41,437,250.53</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>609,123,113.00</b>	<b>777,525,800.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>3,462,600.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>00.00</b>	<b>3,462,600.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	3,462,600.00

1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	912,600.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	2,550,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>609,123,113.00</b>	<b>774,063,200.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	00.00	642,849,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	642,849,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	530,472,700.00	00.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	4,751,513.00	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	73,898,900.00	131,213,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	73,898,900.00	131,213,700.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>609,123,113.00</b>	<b>763,433,523.71</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>609,123,113.00</b>	<b>763,433,523.71</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>592,669,306.00</b>	<b>734,306,009.13</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	421,426,599.00	494,078,385.49
210101	Үндсэн цалин	279,362,285.00	356,195,539.03
210102	Нэмэгдэл	102,092,276.00	119,981,519.55
210104	Урамшуулал	29,892,038.00	14,541,366.91
210105	Гэрээт ажлын хөлс	10,080,000.00	3,359,960.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	55,030,094.00	61,861,995.22
210201	Тэтгэврийн даатгал	38,172,894.00	42,066,214.90
210202	Тэтгэмжийн даатгал	4,214,300.00	4,948,960.97
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,371,400.00	3,959,198.45
210204	Ажилгүйдлийн даатгал	843,000.00	989,799.03
210205	Эрүүл мэндийн даатгал	8,428,500.00	9,897,821.87
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	67,898,900.00	102,176,218.42
210301	Гэрэл, цахилгаан	4,390,182.60	7,277,038.42
210302	Түлш, халаалт	63,208,717.40	94,599,180.00
210303	Цэвэр, бохир ус	300,000.00	300,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	8,371,100.00	00.00
210401	Бичиг хэрэг	376,800.00	00.00
210402	Тээвэр, шатахуун	3,083,300.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	246,000.00	00.00
210404	Ном, хэвлэл	360,100.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,357,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	947,900.00	00.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	26,599,700.00	41,759,410.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	447,200.00	00.00
210502	Хоол, хүнс	24,559,800.00	41,759,410.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,592,700.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	7,200,000.00	2,500,000.00
210604	Урсгал засвар	6,000,000.00	2,500,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	335,800.00	00.00

210702	Дотоод албан томилолт	335,800.00	00.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,428,200.00</b>	<b>5,456,500.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,425,000.00	907,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	600,000.00	4,548,900.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>3,378,913.00</b>	<b>26,473,500.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	19,403,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,378,913.00	7,069,800.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>16,453,807.00</b>	<b>29,127,514.58</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>13,973,734.00</b>	<b>29,127,433.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	12,777,734.00	23,000,339.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,196,000.00	6,127,094.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		0.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>00.00</b>	<b>81.58</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	81.58
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>00.00</b>	<b>14,092,276.29</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>00.00</b>	<b>11,989,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>00.00</b>	<b>11,989,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>00.00</b>	<b>11,989,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	11,989,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>00.00</b>	<b>-11,989,000.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>00.00</b>	<b>2,103,276.29</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>2,103,276.29</b>

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	/төгрөг/	
				Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00

C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00
C08	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>395,974,482.50</b>	<b>226,562,038.72</b>	<b>1,168,319,057.52</b>	1,790,855,578.74
D01	<b>2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>395,974,482.50</b>	<b>226,562,038.72</b>	<b>1,168,319,057.52</b>	1,790,855,578.74
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>395,974,482.50</b>	<b>226,562,038.72</b>	<b>1,168,319,057.52</b>	1,790,855,578.74
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	980.00	00.00	00.00	980.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-41,437,250.53	-41,437,250.53
D09	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>395,975,462.50</b>	<b>226,562,038.72</b>	<b>1,126,881,806.99</b>	1,749,419,308.21

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	897,282,600.00	746,385,042.13	150,897,557.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	897,282,600.00	746,385,042.13	150,897,557.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	707,315,000.00	615,081,390.71	92,233,609.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	494,896,200.00	470,489,585.49	24,406,614.51
210101	Үндсэн цалин	373,209,735.00	339,479,464.03	33,730,270.97
210102	Нэмэгдэл	108,258,565.00	116,468,754.55	-8,210,189.55
210104	Урамшуулал	10,067,900.00	14,541,366.91	-4,473,466.91
210105	Гэрээт ажлын хөлс	3,360,000.00	00.00	3,360,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	61,862,000.00	58,913,395.22	2,948,604.78
210201	Тэтгэврийн даатгал	42,066,214.90	40,061,100.00	2,005,114.90
210202	Тэтгэмжийн даатгал	4,948,961.70	4,713,099.27	235,862.43
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,959,200.00	3,770,498.45	188,701.55
210204	Ажилгүйдлийн даатгал	989,800.00	942,599.03	47,200.97
210205	Эрүүл мэндийн даатгал	9,897,823.40	9,426,098.47	471,724.93

<b>2103</b>	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	160,782,200.00	102,176,218.42	58,605,981.58
210301	Гэрэл цахилгаан	7,664,800.00	7,277,038.42	387,761.58
210302	Түлш, халаалт	152,667,400.00	94,599,180.00	58,068,220.00
210303	Цэвэр, бохир ус	450,000.00	300,000.00	150,000.00
<b>2105</b>	Нормативт зардал	42,816,500.00	41,759,410.00	1,057,090.00
210502	Хоол, хүнс	42,816,500.00	41,759,410.00	1,057,090.00
<b>2106</b>	Эд хогшил, урсгал засварын зардал	2,500,000.00	00.00	2,500,000.00
210604	Урсгал засвар	2,500,000.00	00.00	2,500,000.00
<b>2108</b>	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,620,800.00	5,456,500.00	164,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	907,600.00	907,600.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,713,200.00	4,548,900.00	164,300.00
<b>2109</b>	Бараа үйлчилгээний бусад зардал	41013600.00	38462500.00	2,551,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	33,943,800.00	31,392,700.00	2,551,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,069,800.00	7,069,800.00	00.00
<b>213</b>	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29185400.00	29127433.00	57,967.00
<b>2132</b>	Бусад урсгал шилжүүлэг	29,185,400.00	29,127,433.00	57,967.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	23,058,300.00	23,000,339.00	57,961.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,127,100.00	6,127,094.00	06.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	00.00	777,525,718.42	-777,525,718.42
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	00.00	642,849,500.00	-642,849,500.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	00.00	642,849,500.00	-642,849,500.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>		131,213,618.42	131,213,618.42
132001	Орон нутгийн төсвөөс		131,213,618.42	131,213,618.42
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	00.00	3,462,600.00	-3,462,600.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	912,600.00	-912,600.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	2,550,000.00	-2,550,000.00
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	2,103,276.29	-2,103,276.29
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	01.00	01.00	00.00
610001	Төсвийн байгууллага	01.00	01.00	00.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	35.00	35.00	00.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	00.00
620002	Гүйцэтгэх ажилтан	23.00	23.00	00.00
620003	Үйлчлэх ажилтан	09.00	09.00	00.00
620004	Гэрээт ажилтан	02.00	02.00	00.00

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Давст сумын Ерөнхий боловсролын сургууль нь багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжиж, сургалтын чанар үр дүнг аймгийн дундажаас 3-5%-иар ахиулж, хүүхэд хөгжих таатай орчин нөхцлийг бүрдүүлэхэд чиглэн үйл ажиллагаагаа явуулж байна.

### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Боловсролын тухай хууль - 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрөөс нэмэлт өөрчлөлт оруулсан.
- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль - 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр
- ✓ Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"
- ✓ Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 276 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт
- ✓ Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолын 7 дугаар хавсралт
- ✓ Сангийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар тушаал "Албан томилолтын зардлын тариф" тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Давст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Давст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 42,537.9 мянган төгрөгөөр буюу 0.9 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	2,103.3	2,103.3
Авлага	103.7	3389.4	3285.7
Бараа материал	78,862.6	91,514.3	12,651.7
Үндсэн хөрөнгө	1,713,012.9	1,652,434.4	-60,578.41
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,791,979.2</b>	<b>1,749,441.3</b>	<b>-42,537.9</b>
Өр төлбөр	1,123.6	22.0	-1,101.6
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,790,855.6	1,749,419.3	-41,436.3
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,791,979.2</b>	<b>1,749,441.3</b>	<b>-42,537.9</b>

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 2,103.3 мянган төгрөгөөр өссөн нь Төсвийн шинэчлэл хэрэгжиж улсын төсвөөс санхүүжиж буй байгууллагуудын дансны үлдэгдлийг татан төвлөрүүлэхгүй байх шийдвэр хэрэгжсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 91,514.3 мянган төгрөг болж 12,651.7 мянган төгрөгөөр өссөн нь худалдан авсан хүнс, бичиг хэргийн материалаас шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй болно.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,652,434.4 мянган төгрөг болж 60,578.4 мянган төгрөгөөр буурсан нь 31,934.6 мянган төгрөгийн өртөг бүхий үндсэн хөрөнгө акталсан, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал өссөнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,749,419.3 мянган төгрөг болж 41,436.3 мянган төгрөгөөр буурсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар тайлант үеийн үр дүн нь 41,437.2 мянган төгрөг болж өмнөх оны үр дүнгээс 0.1 хувиар өссөн үзүүлэлттэй.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 701,025.8 мянган төгрөг, нийт зарлагыг 701,025.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 76,500.0 мянган төгрөгөөр өсгөж баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 777,525.8 мянган төгрөгийн төсөв баталснаас 646,312.1 мянган төгрөгийг улсын төсвөөс, 131,213.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 646,312.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 131,213.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд улсын төсвийн 644,208.8 мянган төгрөгийг зарцуулж, улсын төсвийн дансанд 2,130.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
	Улсын төсвөөс	646,312.1	644,208.8	2,103.3	99.7%
	Орон нутгийн төсвөөс	131,213.7	131,213.6	0.08	100%

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 644,208.8 мянган төгрөг буюу 99.7 хувьтай байгаа нь цалин урамшууллын зардлыг 2,039.2 мянга, хоол хүнсний зардлыг 64.1 мянган төгрөгөөр хэмнэж зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд Давст сумын Ерөнхий боловсролын сургуулийн нэмэлт санхүүжилтийн дансаар орлого, зарлага гараагүй байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Давст сумын Ерөнхий боловсролын сургууль нь тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Давст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Увс Финанс Аудит” ХХК-ийн аудитор Я.Тунгалаг гүйцэтгэж, анхан шатны хяналтыг захирал Я.Нарантуяа, чанарын хяналтыг Увс аймгийн Төрийн аудитын газрын аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Давст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Увс Финанс Аудит” ХХК –д 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 01 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 742.4 сая төгрөгөөс 1 хувиар буюу 7.1 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 831.7 сая төгрөгийн 1 хувиар буюу 8.3 сая төгрөгөөр тогтоосон.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Давст сумын Ерөнхий боловсролын сургуулийн хувьд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хамаарах зүйл заалтын хүрээнд зөрчил гараагүй байна. /АБ-4/

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор

www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс байршуулах хугацаа болоогүй 2, хугацаа хоцроож 3, хугацаандаа оруулсан 146 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилт

Давст сумын Ерөнхий боловсролын сургууль нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэгт “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Давст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж өгөөгүй байна.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Давст сумын Ерөнхий боловсролын сургуулийн хувьд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  /М.БАТСУУРЫ/

АУДИТЫН МЕНЕЖЕР  /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

“УВС ФИНАНС АУДИТ” ХХК-ИЙН  
АУДИТОР 

/Я.ТУНГАЛАГ/

2023 оны 02 дугаар сарын 15-ны өдөр